БАТЛАВ. "ДӨРВӨЛЖ" ОНӨААТҮГ-ЫН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ТҮВШИНДЭЛГЭР

# ДӨРВӨЛЖ / ОНӨААТҮГ/ -ЫН АЖИЛЧДЫН АЖЛЫН ТУСГАЙ ГУТЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2023 оны 06 сар

Уг бараag нийлүүлэх компани нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- ✓ Тендерийн бичиг баримтад заасан тооны гуталны чанар нь захиалагчид ирүүлсэн 1 ком загварын гуталнаас, материал, чанар ( гараар мэдрэхэд ялгаагүй), өнгө, хийцийн хувьд ялгаагүй, өнгө зөрүүгүй, адил байна. Ялгаа гарсан тохиолдолд Захиалагч ирүүлсэн гутлыг бүгдийг Гүйцэтгэгчид бөөнөөр буцааж, тендерийн бичиг баримтад заасан, шаардлага хангасан гутлаар солиулна.
- ✓ Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.
- ✓ Хөл хамгаалах хэрэгсэлд олон улсын холбогдох стандарт хангасан, хүний биед харшил үүсгэх, арьс салстыг цочроох үйлдэлгүй болохыг нотлох мэргэжлийн байгууллагын сертификат, тодорхойлолт ( дүгнэлт)- тэй байна.
- ✓ Хөл хамгаалах хэрэгслийг хийсэн эсхүл тоонд орсон материал бүр нь хүний биед сөрөг нөлөөгүй, аливаа цочрол, шархлаа үүсгэхээргүй, биеийн хөлстэй урвалд орох чанаргүй зориулалтын хувцасны материалаар хийгдсэн байна.
- ✓ Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар стандартын үзүүлэлтээс давсан, илүү сайн чанар, үзүүлэлттэй байвал давуу тал болно.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

| | | |
|---|---|---|
| 1.1 | Тусгай шаардлага | Размер бүрээр 1,1 ш захиалагчид ирүүлж гутлын өмсгөлөөс хамаарч нийт размерыг тодорхойлох боломжтой байх эсхүл гутлын размер таарахгүй тохиолдолд нийт гутлын тооны 30 %-д размерын өөрчлөлт хийх боломжтой байна. |
| 1.2 | Өнгө / ИТАжилчид / | Бор шаргал , |
| 1.2 | Өнгө / Ажилчид / | Бор шаргал, |
| 1.3 | Материал | Гадна тал 100% шир ( water repellent nubuck) эсхүл түүнээс сайн нийлэг материал, дотор тал чийг татдаггүй, хөл холгохоос сэргийлсэн, битүү нэхий эсхүл дулаан тусгаарлагч материалаар хийгдсэн дотортой байна. Хүйтэнд тэсвэртэй, халтирдаггүй, зузаан ултай байна. Бүх хэсгүүд нь хүйтний улиралд тохирсон олон улсын стандарт шаардлага хангасан материалаар хийгдсэн байхаас гадна хүйтнээс хамгаалах доторлогоо болон дулаалга нь байгалийн гаралтай ноос, үс болон түүнээс дутуугүй үзүүлэлттэй нийлэг материал байна.<br>Улавч нь чийг шингээгчтэй эсхүл агаар нэвтрүүлэх хөлрөхөөс хамгаалах материалтай байна. |
| 1.4 | Чанар | Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна. Хэрэглээний болон технологийн тодорхойлолтонд хэрхэн нийцсэн, хүний биед таарч байгаа байдлаар тодорхойлогдоно.<br>Оёдол болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна.<br>Олон улсын стандартын шаардлага хангасан, чанартай хамгаалалтын гутал байна. |
| 1.5 | Ангилал | хагас түрийтэй үдээстэй, үдээсгүй |
| | | Гутлын хоншоор, ул болон зуузай хэсэг нь хүний хөлийг гэмтлээс хамгаалсан хамгаалалттай, металл агуулаагүй байна. ( S3 стандарт ).<br>хамгаалалт нь + 60ºC - -40ºC-т 200 жоул хүртэлх хүчний хатгалт, цохилт, даралтыг тэсвэрлэх чадвартай байна. ( S3 |

| | | |
|---|---|---|
| 1.6 | Үзүүлэлт | стандарт).<br>Зуузайны хамгаалалттай, шагайны хэсгийг хамгаалсан нэмэлт зөөлөвчтэй байна ( S3 стандарт).<br>Гутлын ул хөлддөггүй, халтирдаггүй, хугардаггүй байна ( S3 стандарт).<br>Улавч нь доргион шингээгчтэй уян, өсгий хэсэгтээ 15 мм-ээс нимгэнгүй, нимгэн хэсэгтээ 3 мм-ээс нимгэнгүй хөлийн анатомийн хэлбэрт тохирсон, температур тусгаарлагч чанартай байна.<br>Гадна хийц болон зуузайны хэсгүүд нь нүхгүй, шороо тоос чигжихгүй материалаар хийгдсэн байна.<br>Доргилтоос хамгаалсан өсгийтэй байна.(S3 стандарт)<br>Гутал нь дээрхи чанарын үзүүлэлтийг үзүүлсэн үйлдвэрлэгчийн шошго тэмдэгтэй байна. Шошгонд үйлдвэрлэсэн үйлдвэрлэгч, хийгдсэн материал, цахилгаанаас тусгаарладаг эсэх зэргийг тодорхой бичсэн байна. Үйлдвэрлэгчийн шошго нь Англи хэл дээр байж болох ба Хятад хэл дээрхи шошгыг заавал Монгол хэл рүү орчуулж хавсаргасан байна. / Эсхүл түүнтэй дүйцэх/ |
| 1.7 | Хэмжээ | 36-46 размер байна. |
| 1.8 | Стандартууд | Хөл хамгаалах хэрэгсэл нь Монгол улсын<br>• MNS5623: 2006<br>• олон улсын EN ISO20345:2011 S3<br>• EN ISO 20347: 2012<br>• EN 12568: 2010<br>• CEI EN 61340-5-1:2008<br>• MNS 6764: 2019<br>• MNS0078:1988 эдгээр шаардлагуудыг хангасан байх |

**Үндсэн шаардлага:**

Ажлын өвлийн гутал нь бохирдол, механик нөлөөлөл, хүйтэн температур зэрэг үйлдвэрлэлийн гэмтэл болон хүрээлэн буй орчны тааламжгүй хүчин зүйлээс хамгаалах зориулалттай байна. Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Үүнд :

- ✓ Ажлын гутал нь зориулалтын шаардлага хангасан, хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хэвтэй, хүний эрүүл мэндэд тохирсон байх
- ✓ Механик биет, химийн бодис, цахилгаан, ус чийг, хүйтний нөлөөлөл, онцгой нөхцөлд тохиолдож магадгүй болзошгүй осол, гэмтлээс хөлийг хамгаалах
- ✓ Өвлийн дотортой гутал учраас хамрын төмөр биш PVC материалаар хийгдсэн хатуулгатай
- ✓ Хуруу, шагайн хамгаалалттай, 200 хүртлэх джоулын цохилтын хүчийг даах тэсвэртэй
- ✓ Цэвэр нэхий дотортой, -30С хүртлэх агаарын хэмд өмсөхөд зориулагдсан байх
- ✓ Гадар нь цэвэр арьсан материалтай, хөлддөггүй, эдэлгээ удаантай
- ✓ Гутлын ул нь зузаан, хальтардаггүй, хугардаггүй, цоордоггүй,/ Kewlar/ шахмал резинэн материалаар хийгдсэн байх
- ✓ Өвлийн ажлын гутал дараах стандартын шаардлага хангасан байх. Үүнд: EN ISO 20345: 2021 стандартын S3 ангилал, ASTM F 2413-18 M/I/C SD, MNS 5623:2006 , MNS 6764:2019
- ✓ Өвлийн ажлын гуталнууд цэвэр ширэн материалаар хийгдсэн, ширэн улавчтай байна.
- ✓ Хатуулгатай зуузайтай, давхар оёдолтой.
- ✓ Өмсөхөд хялбар хөлд эвтэйхэн резинэн түрийтэй
- ✓ Үхрийн дээд зэргийн ширэн материалтай байх
- ✓ Ус үл нэвтрэх материалаар бүтээгдсэн байх
- ✓ Доргио шингээгч бүхий 3 давхар резинэн ултай байх
- ✓ Цахилгаан дамжуулдаггүй, шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй

## Гутлын тоо ширхэг размер

| № | Барааны нэр | Цех хэсэг | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дулааны станц | Эмнэлгийн зуух | 24-н зуух | Авто техникийн хэсэг | ДШСЗасвар | Усан хангамж | АТШСЗасвар | Цэвэрлэх байгууламж /лаб/ | Ус цэвэршүүлэх | ХҮАлба | ДШУАлба | Цахилгааны хэсэг | Ус түгээх хэсэг | Захиргаа аж ахуй | Нөөцөнд | Нийт дүн |
| Ажилчдын зуны тусгай гутал /хос/ | | | | | | | | | | | | | | | | | |
| | 43 | 0 | 0 | | 1 | | 1 | | | | 1 | | | | | | 3 |
| | 42 | 3 | 2 | | 4 | | | 1 | | | | | 1 | | | | 11 |
| | 41 | 7 | 3 | 2 | 6 | 1 | | 2 | 1 | | 1 | 1 | 1 | | | | 25 |
| | 40 | 9 | 8 | 11 | 5 | 3 | 2 | 3 | 4 | | 5 | 3 | 1 | 2 | | | 56 |
| | 39 | 5 | 10 | 1 | 3 | 5 | 2 | 4 | | | 2 | | | 1 | | | 33 |
| | 38 | 0 | 2 | 7 | | | | 2 | | 1 | | | | 2 | | | 14 |
| | 37 | 0 | 0 | | | | 1 | | 1 | 1 | | | | 1 | | | 4 |
| | 36 | 0 | 0 | | | | | | | | | | | 1 | | | 1 |
| | Нийт дүн | **24** | **25** | **21** | **19** | **9** | **6** | **12** | **6** | **2** | **9** | **4** | **3** | **7** | **0** | **0** | **147** |

| ИТА-н зуны тусгай гутал /хос/ | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 43 | | | 1 | | | | | | | | | | | | | 1 |
| | 42 | 2 | 1 | | | | | | | | | | | | | | 3 |
| | 41 | 1 | | | | 3 | 1 | | 3 | | | 2 | 1 | | 2 | | 13 |
| | 40 | 3 | | 1 | | | | 1 | | | | | 1 | | 3 | | 9 |
| | 39 | 1 | | | 2 | 1 | | | 2 | | 3 | 2 | | | 5 | | 16 |
| | 38 | 1 | | | | | | | 2 | | 4 | | | | 1 | | 8 |
| | 37 | | | | | | 1 | | 1 | | 1 | | | | 2 | | 5 |
| | 36 | | | | | | | | 2 | | 3 | | | | 3 | | 8 |
| | Нийт дүн | **8** | **1** | **2** | **2** | **4** | **2** | **1** | **10** | | **11** | **4** | **2** | | **16** | | **63** |
| Нийт | | | | | | | | | | | | | | | | | **210** |

## Ажлын гутал / багц-1/-ын тоо хэмжээ

| д/д | Нэр төрөл | х/н | тоо, хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Ажлын гутал / Өвлийн/ Ажилчид | хос | **147** |
| 2 | Ажлын гутал / 4-н улирлын / ИТА | хос | **63** |

1.Ангилал:

- Хагас урт түрийтэя ажлын гутал
- Богино түрийтэй ажлын гутал

| № | Нэр төрөл | Зориулалт |
|---|---|---|
| **1** | Хагас түрийтэй ажлын гутал | ИТА , конторын ажилчид |
| 2 | Хагас түрийтэй ажлын гутал | Ажилчид |

ИТА-н гуталны загвар:



TREX PRO
DISCOVERED 1905

## ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АЖЛЫН ГУТАЛ
## ЗАГВАР № 251

TREX PRO
DISCOVERED 1905

### ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛУУД

- Өмсөхөд хялбар хөлд эвтэйхэн резинэн түрийтэй
- Coolmax брэндийн чийг татдаггүй дотортой.
- Үхрийн дээд зэргийн ширэн материалтай.
- Хурууны ган төмөр хамгаалалттай.
- Ус үл нэвтрэх материалаар бүтээгдсэн.
- -10 оос +34 хэмд өмсөх боломжтой
- Coolmax брэндийн зөөлөвч бүхий зузаан улавчтай.
- Доргио шингээгч бүхий 3 давхар резинэн ултай.
- Цахилгаан дамжуулдаггүй, шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй
- Хөнгөн, бат бөх, хөдөлгөөнд үл саад болох загвартай.
- Размер сонголт: 36-43 размер



**S3** СТАНДАРТ



**TREX PRO®**
DISCOVERED 1905

Тусгай зориулалттай ажлын гутал нь уул уурхай, хүнд үйлдвэрлэл, барилга угсралт, автозам гэх мэт бүтээн байгуулалтын салбарын ажилтнуудад зориулан дэвшилтэд технологийн материал, аргачлалаар бүтээгдсэн.

**TREX PRO®**
DISCOVERED 1905

Тусгай зориулалттай ажлын гутал нь хүйтэн нөхцөлд ажиллахад зориулагдсан, тос, ус чийг, тоос шороо, химийн бодис, шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй, чийг татдаггүй байх ба арзгар, зузаан халтирахгүй ултай, хуруууны хамгаалалттай, хөдөлгөөнд саадгүй түрийн зохион байгуулалттай, бат бөх, цахилгаан дамжуулдаггүй онцлогтой.



**TREX PRO®**
DISCOVERED 1905

## ГУТЛЫН СТАНДАРТ

**EN ISO 20345:2011**
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл
Ажлын гутал

**EN ISO 20347:2012**
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл
Тусгай зориулалттай ажлын гутал

**EN 12568:2010**
Хөлийн /хуруувны/ хамгаалалт

**CEI EN 61340-5-1:2008**
Цахилгаан статик. Ажлын байрны хүчдэлийн зөвшөөрөх түвшинд хамаарах гутал

**MNS 6764 : 2019**
Гутлын олон нугаралт тэсвэрлэх чадвар.

**MNS0078:1988**
Ерөнхий техникийн шаардлага

**MNS5623:2006**
Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал зэрэг олон улсын болон Монгол Улсын стандартад мөрдөгдөж буй шаардлагыг бүрэн хангасан.




**TREX PRO®**
DISCOVERED 1905